

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай 19.18 дугаар зүйл нэмсүгэй:

**“19.18 дугаар зүйл. Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн
бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилгоор
ард нийтийн санал асуулга явуулах**

1. Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахаар олон нийтэд уриалсан, санаачилсан, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, эсхүл бэлтгэсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж;

2.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван жил хүртэл хорих ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн Тайлбарын “тагнуул,” гэсний дараа “авлигатай тэмцэх” гэж, 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “торгох,” гэсний дараа “эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах,” гэж, 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “өөртөө,” гэсний дараа, 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Өөртөө,” гэсний дараа “эсхүл” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/7.5 дугаар зүйл:

“7.5 дугаар зүйл. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ

1. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл гэмт хэргийн улмаас бусдад хохирол учруулсан бол тухайн хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн өөрт нь ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хураана.

2.“Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг орлогыг ойлгоно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу албадан гаргуулж хураасан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна.

4.Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бараа, эд зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч улсын төсөвт, эсхүл хууль ёсны өмчлөгчид шилжүүлэх, хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.

5.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн, эсхүл бусдын тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг өмчлөгчид нь мэдэгдэхгүйгээр ашиглаж гэмт хэрэг үйлдсэн бол шүүх тухайн эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн өөрт нь ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж, хураана.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого болохыг мэдсээр байж авсан, эсхүл тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, орон байраар хангаж гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн болох нь тогтоогдвол шүүх тухайн хөрөнгө, орлого гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, орон байрыг хураана.

6.Шүүх хураан авах хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг бүрчлэн заана.

Тайлбар – энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан “гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан” гэсэн нь энэ хуулийн Хориндөрөв дүгээр бүлэгт заасан Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт хамаарахгүй.”

2/13.14 дүгээр зүйл:

“13.14 дүгээр зүйл.Худал мэдээлэл тараах, түгээх

1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдаж гутаах, эсхүл олон нийтийг төөрөгдүүлэх, эсхүл айдаст автуулах зорилгоор хортой, илтэд худал мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн мэдээллийн сүлжээний хэрэгсэл ашиглан тараасан, эсхүл илтэд худал мэдээлэл болохыг мэдсээр байж түгээсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.захиалгаар;
2.2.хүүхдийн эрхийг зөрчиж;
2.3.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж;

2.4.гамшиг, цар тахлын үед үнийн хөөрөгдөл, бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдолыг бий болгож;

2.5.сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж үйлдсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг, эсхүл Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

3/21.11 дүгээр зүйл:

“21.11 дүгээр зүйл.Оргон зайлах

1.Яллагдагч, шүүгдэгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсхийсэн бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Цагдан хоригдсон яллагдагч, цагдан хоригдсон шүүгдэгч, эсхүл хорих ял шийтгүүлсэн ялтан оргон зайлсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

4 дүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил” гэснийг “таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил” гэж, мөн зүйлийн 2.2 дахь заалтын “зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил” гэснийг “нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил” гэж, 13.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил” гэснийг “зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил” гэж,

22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар” гэснийг “гурван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж” гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 326 дугаар зүйлд дараахь агуулгатай 326.3 дахь хэсэг нэмсүгэй:

“326.3.Түрээслэгч нь түрээсэлсэн эд хөрөнгийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашигласан бол гэм буруугийн хэлбэрээс үл шалтгаалан эд хөрөнгөд учирсан хохирлыг хариуцан барагдуулна. Учруулсан хохирлоо түрээслүүгчтэйгээ тохиролцон бүрэн болон хэсэгчлөн төлнө.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.12 дахь заалтын “хүнийг” гэснийг “хүн, хуулийн этгээдийг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
Сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ард нийтийн санал асуулгын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дараахь агуулгатай 4.4 дэх хэсэг нэмсүгэй:

“4.4. Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэхтэй холбоотой асуудлаар ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг